МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 01 өдөр Дугаар А/34 Мөрөн сум

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 60.1.17, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.6, Сангийн сайдын 2014 оны 65 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумдын төрийн сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийх 2023 оны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Сумдын төрийн сангийн дотоод хяналтыг батлагдсан удирдамжийн дагуу үр дүнтэй зохион байгуулж, үр дүнг нэгтгэн аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Базар)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ДАРГА Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Захирамж 2023

6712010701

Аймгийн Засаг даргын 2023 оны 02
дүгээр сарын 01-ны өдрийн А/34 дугаар
захирамжийн хавсралт

СУМДЫН ТӨРИЙН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ДОТООД ХЯНАЛТ ХИЙХ 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Сумын нэр	Дотоод хяналтад хамруулах шалтгаан	Хугацаа
1	Ханх	Санхүүгийн албаны дарга, төрийн сангийн мэргэжилтнийг нэг албан хаагч хавсран гүйцэтгэж байгаа, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн.	2 дугаар сард
2	Алаг-Эрдэнэ	Дотоод хяналт хийх шаардлагатай.	3 дугаар сард
3	Их-Уул	Санхүүгийн албаны дарга, төрийн сангийн мэргэжилтэн шинээр томилогдсон.	4 дүгээр сард
4	Түнэл	Санхүүгийн албаны дарга, төрийн сангийн мэргэжилтнийг нэг албан хаагч хавсран гүйцэтгэж байгаа.	4 дүгээр сард
5	Жаргалант	Дотоод хяналт хийх шаардлагатай, өндөр эрсдэлтэй үнэлэгдсэн.	5 дугаар сард
6	Галт	Дотоод хяналт хийх шаардлагатай, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн.	5 дугаар сард
7	Цагаан-Үүр	Дотоод хяналт хийх шаардлагатай, өндөр эрсдэлтэй үнэлэгдсэн.	6 дугаар сард
8	Рашаант	Дунд эрсдэлтэй үнэлэгдсэн.	7 дугаар сард
9	Эрдэнэбулган	Дунд эрсдэлтэй үнэлэгдсэн.	7 дугаар сард
10	Мөрөн	Дотоод хяналт хийх шаардлагатай, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн.	8 дугаар сард

_____oOo_____